

АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗӨВЛӨМЖ (2024 он)

Аюулгүй ажиллагааны зөвлөмж 202401/01. ИНЕГ-т, Монголиан Эйрвэйс ХХК, нисдэг тэрэг ашиглагч нарт. /Safety recommendation 202401/01. МСАА, Mongolian Airways LLC and /.

Өмнө өгсөн Аюулгүй ажиллагааны зөвлөмж 202211/07-ийн хэрэгжилт хангалтгүй байсан нөхцөл илэрсэнтэй холбогдуулан хөөрөлтийн дээд жин 5700 кг-аас бага жинтэй ганц-хөдөлгүүртэй нисдэг тэрэгний маягийн зэрэглэл эзэмшигч нь тухайн агаарын хөлөг дээр нислэгийн туршлага хурамтлуулаагүй бол нисгэгчийг нислэгийн үйл ажиллагааны заавар/section 3 Emergency procedures/-ын онолын болон дадлагажуурын сургалтанд бүрэн хамруулж энэ категорийн эрх авсан багш нисгэгч, шалгагчаар эрхийг баталгаажуулах.

Аюулгүй ажиллагааны зөвлөмж 202411/02. ИНЕГ-т. /Safety recommendation 202411/02. МСАА/.

“Монгол Улс Хэт хөнгөн агаарын хөлгийг суудлаар ангилсан боловч жин болон нислэгийн бусад үзүүлэлтээр ангилаагүй байгаа тул энэ төрлийн агаарын хөлгийг ангилж байгаа олон улсад нийтлэг мөрдөж байгаа туршлагад үндэслэн Хэт хөнгөн агаарын хөлгийг ангилахдаа хөөрөлтийн дээд жинг 600 кг-аас доош жингээр, мөн Stall-д орох хурдаар судлан тогтоож өгөх”.

Аюулгүй ажиллагааны зөвлөмж 202411/03. ИНЕГ-т. /Safety recommendation 202411/03. МСАА/.

“Хэт хөнгөн агаарын хөлгийн нисгэгчдийг Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас нисгэгчийн үнэмлэх, зэрэглэл болон эрүүл мэндийн гэрчилгээ олгох тогтолцоог бүрдүүлж тэдний сургалт болон эрүүл мэндэд тавигдах шаардлагад хяналт тавих”.

Аюулгүй ажиллагааны зөвлөмж 202411/04. ИНЕГ-т. /Safety recommendation 202411/04. МСАА/.

“Жижиг болон Хэт хөнгөн агаарын хөлгийн нисгэгчдэд Stall-д орох нөхцөл байдлын сургалтыг зохион байгуулж, шалгалт авах”.

Аюулгүй ажиллагааны зөвлөмж 202411/05. ИНЕГ-т. /Safety recommendation 202411/05. МСАА/.

“Жижиг болон Хэт хөнгөн агаарын хөлгийн нисгэгчдэд жин төвлөрөлтийн тооцоо хийх аргачлалд суралцуулж, шалгалт авах”.

Аюулгүй ажиллагааны зөвлөмж 202411/06. ИНЕГ-т. /Safety recommendation 202411/06. МСАА/.

“Жижиг болон Хэт хөнгөн агаарын хөлгийн ашиглагч/эзэмшигчийн Нислэгийн ашиглалтын зааврын ашиглалт болон үйлдвэрлэгчийн шаардлагыг дагаж мөрдөж байгаа байдалд хяналт тавих”.

Аюулгүй ажиллагааны зөвлөмж 202411/07. ИНЕГ-т. /Safety recommendation 202411/07. МСАА/.

Хэт хөнгөн агаарын хөлгийн жолоо удирдлагаар хангагдсан суудалд зорчигч тээвэрлүүлэхгүй байх тогтолцоог бүрдүүлэх.

Аюулгүй ажиллагааны зөвлөмж 202412/08. ИНЕГ-т. /Safety recommendation 202412/08. МСАА/.

Хэт хөнгөн ангилалд хамаарагдах агаарын хөлгөөр зорчигч тээвэрлэхгүй байх түүний ашиглах зориулалтыг олон улсын жишигт нийцүүлэн зөвхөн спорт ба аялалын/Sport or recreation use only/ зориулалтаар ашиглах зохицуулалт хийх.

Аюулгүй ажиллагааны зөвлөмж 202412/09. ИНЕГ-т. /Safety recommendation 202412/09. МСАА/.

Иргэний нисэхийн ИНД-149 дүрмийн агуулга, шаардлага нь нислэгийн сургалтыг зохион байгуулахад нийцэхгүй байгааг анхааран үзэж шинэчилэн боловсруулж зориулалтыг зөв болгох, үүнтэй холбогдуулан өмнө нь энэ дүрмээр гэрчилгээжсэн байгууллагуудыг шинэ нөхцөл байдалд уялдуулан шалгаж баталгаажуулах.

Аюулгүй ажиллагааны зөвлөмж 202412/10. ИНЕГ-т. /Safety recommendation 202412/10. МСАА/.

ИНЕГ-аас Хэт хөнгөн агаарын хөлгийн ашиглалттай холбогдуулан олгосон зөвшөөрөл болон зохицуулалтын дүрмийн биелэлтэнд хяналт тавих тогтолцоог сайжруулах.